

The Defacto Gazette

МЭДЭЭЛНЭ

| ЗОРИГЖУУЛНА

| МЭДЭЛЖҮҮЛНЭ

Баасан, 2019.12.20, №12 (128)

УЛС ТӨР, ЭДИЙН ЗАСГИЙН ДҮН ШИНЖИЛГЭЭНИЙ, БИЕ ДААСАН,
УЛС ТӨРИЙН НАМААС ХАРААТ БУС, ДОЛОО ХОНОГ ТУТМЫН ГЛОБАЛ СОНИН

www.jargaldefacto.com

WEEKLY



ДеФакто **НИЙТЛЭЛ**
№508

Д.Жаргалсайхан
Эдийн засагч, нийтлэлч

Төрийн бус байгууллага ба СААРАЛ ЖАГСААЛТ



Европын Холбооны Гадаад бодлого, аюулгүй байдлын
Дээд төлөөлөгч бөгөөд Европын Комиссын Дэд
ерөнхийлөгч Жосеп Боррелийн илгээлт

"ЕВРОП БОЛОН АЗИ ТИВИЙН ХАМТЫН ХҮЧИЙГ БОДИТ ТҮНШЛЭЛ РҮҮ ХӨТЛӨХ ЦАГ НЬ НЭГЭНТ БОЛСОН"

IV НҮҮРТ

ДеФакто **ТОЙМ**

➤ **МОНГОЛ УЛС ХҮНИЙ
ХӨГЖЛИЙН ӨНДӨР
ҮЗҮҮЛЭЛТТЭЙ ОРОНД БАГТЛАА**

➤ **ЗАСГИЙН ГАЗРЫН
ШИЙДВЭРҮҮД ЯАГААД
БУЦДАГ БОЛЧИХОВ ОО?**

➤ **САЙД Ц.НЯМДОРЖИЙН
ХҮҮЛЬЧДЫН ХОЛБООГ ТАТАН
БУУЛГАХ САНАЛ**

VI НҮҮРТ

Төрийн бус байгууллага ба СААРАЛ ЖАГСААЛТ



Монгол улс Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх олон улсын байгууллага (FATF)-ын хяналтын буюу "саарал" жагсаалтад ороод хоёр сарын нүүр үзэж байна. Энэ чиглэлийн өндөр эрсдэлтэй орнуудын тоонд яагаад орсон, яах ёстой тухай "Саарал төр", "Саарал шүүх", "Саарал нийгэм" зэрэг цуврал нийтлэл бичиж уншигчиддаа хүргэсэн.

Эдүгээ монголын төр засгийн түшээд саарал жагсаалтаас гарах амлалт, үүрэг авснаа зөвхөн өөрийн иргэд, олон нийтэд төдийгүй дэлхийн бусад орнуудад зарлаад байна. Өнгөрсөн сард монголын хууль тогтоогчид саарал жагсаалтад оруулсны хариуцлагыг хүлээлгэж Төв банк болон Санхүүгийн Зохицуулах Хорооны тэргүүнүүдийг халж, орлогчдоор нь сольчихоод байна.

ФАТФ-ийн мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхийн эсрэг гаргасан зөвлөмж нь олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн стандарт болж, санхүүгийн системийг нь буруу зорилгоор ашиглахын эсрэг үр дүнтэй арга хэмжээ авах чухал хэрэгсэл болж иржээ. Улс орны нийгэм, улс төр, эдийн засгийн бараг салбар бүрийг хамарсан мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхийн эсрэг тусгай 9, нийт 40 зөвлөмж байдаг. ►►

- ▶ Эдгээрийн дотроос иргэний нийгэм, ашгийн бус салбарт шууд хамааралтай нь 8-р зөвлөмж юм. ФАТФ 40 зөвлөмж тус бүрээрээ тухайн орны үйл ажиллагаанд бас үнэлгээ (Нийцсэн – С, Ихэнх нь нийцсэн – LC, Хэсэгчлэн нийцсэн – PC, Огт нийцээгүй – NC зэргээр) дүгнэлт өгдөг.

СААРАЛ ЖАГСААЛТЫН ЦААНА

Энэхүү стандартын дагуу Монгол улсад 2007, 2017 онд хоёр удаа үнэлгээ хийлгэжээ. Хоёулангаар нь монголын ашгийн бус байгууллагын салбарыг “хэсэгчлэн нийцсэн” гэж дүгнэжээ. Тэгвэл саяхан нэмэлт үнэлгээ хийлгэж, тайлан (follow-up) нь хоёр сарын өмнө гарав. 2017 оны тайланд тодорхой салбар бүрээр үнэлгээ хийх зөвлөгөө өгч, ялангуяа хамгийн эрсдэлтэй гэж ашгийн бус салбарыг онцлон, энэ салбарыг хамарсан бүрэн хэмжээний үнэлгээ хийхийг зөвлөж байжээ. Гэтэл Монгол улс энэ үнэлгээг одоо болтол хийхгүй байгаад гайхаж байна гэж уг нэмэлт үнэлгээний тайланд дурджээ.

ФАТФ улс орон бүрээр тайлан гаргадаг ба монголын ашгийн бус салбарын тайланд эрсдэл болон авах арга хэмжээг дүгнэхдээ:

- Ашгийн бус салбарынхаа эрсдлийг бүрэн гүйцэд үнэлж дүгнээгүй
- Эрсдэлтэй ТББ-ууддаа мэдээлэл хүргэж, таниулах ажил хийгээгүй
- Ашгийн бус салбарын хяналт тодорхой бус
- Ашгийн бус салбарт авах хориг нь тодорхой биш, хэрэгт нь тохирсон биш
- Хууль хяналтын байгууллагын ашгийн бус салбарыг шалгах мэдлэг, чадвар хангалтгүй
- Ашгийн бус салбартай холбоотой өмнөх хяналт шалгалтын баримт, нотолгоо гаргаж өгөөгүй гэсэн байна.

ФАТФ-ИЙН ҮНЭЛГЭЭНИЙ ЦААНА

Дээрх үнэлгээг монголчууд нухацтай, болгоомжтой авч үзэх шаардлагатай байна. ФАТФ болон бусад олон улсын байгууллагуудаас ТББ-уудад тавьж буй шаардлагууд нь иргэний нийгмийн орон зайг хязгаарлах, тэр дундаа төрийн зүгээс хяналт, шалгалтыг тогтмол хийдэг болохыг шаардаж байна.

Ер нь эдүгээ ТББ үйл ажиллагаагаа явуулах орон зайг дэлхий нийтээр хязгаарлах хандлага бий болоод байна. Олон улсын терроризмын эсрэг хууль журмууд нь, ялангуяа ФАТФ мөрдөхийг шаардах болсон журмууд нь бүр анхнаасаа ардчилсан оролцоог хангаж чадаагүй, маш хурдан хугацаанд гаргасан учраас хүний суурь эрхийг хангах тал дээр учир дутагдалтай гэж судлаач Бен Хэйс (2017) бичжээ. Б.Хэйс ТББ-аар дамжуулж мөнгө угаасан, терроризмыг санхүүжүүлсэн гэдэг нь батлагдсан тохиолдол дэлхий нийтэд маш ховор гэж хэлжээ. Харин ФАТФ –ийн зөвлөмжийг биелүүлэх нэрийн дор ТББ-ын

хуулиа өөрчилж, иргэний нийгмийнхээ дуу хоолойг хязгаарласан орнуудын тоо нэмэгдсээр байна. Жишээ нь Босни Герцеговина, Хорват, Македони, Унгар, Энэтхэг, Казахстан, Киргизстан, Польш, Серби, Тажикстан (Hayes, 2017) зэрэг орнуудыг энд хэлж байна.

Төрийн хяналт ба олон улсын институтээс ФАТФ-ын 8-р зөвлөмжтэй холбоотой үнэлгээг 159 орныг хамруулан 2012 онд хийсэн байна. Энэ үнэлгээгээр нийт улс орнуудын 85 хувь нь нийцэлгүй (no compliant), эсвэл хагас нийцэлгүй (partially compliant) гэж гарчээ. Төв Европын олон орон мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй холбоотой хуулиа өөрчилсөн боловч, үнэлгээ нь мөн л 8-р зөвлөмжтэй нийцэлгүй гэж гарсан нь анхаарал татаж байна. 2007 онд анх дэлхийн 158 оронд үнэлгээ хийснээс ердөө таван орны (Бельги, Египет, Итали, Тунис, АНУ) ашгийн бус салбар зөрчил дутагдал илрээгүй буюу “нийцсэн” дүгнэлт авчээ.



► Энэ бол “9-р сарын 11”-ний террорист халдлагаас хойш ашгийн бус байгууллагаар дамжуулж терроризмыг санхүүжүүлж байна гэх хардлага ихэд дэлгэрсэнтэй холбоотой. Тухайн үед АНУ-ын Ерөнхийлөгч Жорж Буш ТББ-уудыг буруутгасан мессежийг олон нийтэд хүргэж байсан. Улмаар ашгийн бус байгууллагад хамаарах хууль тогтоомжуудаа судлан дүгнээд, энэ төрлийн байгууллагуудыг терроризмыг санхүүжүүлэхэд урвуулан ашиглах эрсдлээс урьдчилан сэргийлэхийг олон улсын байгууллагууд шаардаж эхэлсэн юм. Энэ нь дэлхий даяар иргэний нийгэмд хамаарах хууль тогтоомжуудаа өөрчлөх давалгааг эхлүүлэв. Гэвч олон орны мөнгө угаах, терроризмын эсрэг хууль тогтоомж огт сайжраагүй ажээ.

Дээр дурдсан 2017 оны үнэлгээнд 89 орон хамрагдсан. Тэдгээрээс зөвхөн дөрвөн орон (Армян, Хонг Конг, АНУ, Их Британи) 8-р зөвлөмжид “нийцсэн” үнэлгээ авсан байна. Харин 60 орон “хэсэгчлэн нийцсэн”, эсвэл “огт нийцээгүй” үнэлгээ авчээ.

ФАТФ-ын зөвлөмжийг хэрэгжүүлэхийн тулд ТББ-уудтай холбоотой хууль тогтоомждоо ганц, нэг өөрчлөлт оруулах биш, юуны өмнө энэ салбарыг хамарсан, цогц үнэлгээ хийх хэрэгтэй байна. Дараа нь мөнгө угаах, терроризмийг санхүүжүүлэх эрсдэл өндөртэй гэж үзсэн байгууллага тус бүртэй уулзаж, хамтран ажиллах шаардлагатай.

2019.12.18

CHAMPAGNE
Nicolas Feuillatte
FRANCE

Халигийн сайхан хүслээ
шивнээрэй !

WORLD WINE
ДЭЛХИЙД АЛДАРТАЙ ДАРСНЫ АМТ
7777 4747

Palmes d'Or
CHAMPAGNE
NICOLAS FEUILLATTE
750ml 125cl

Европын Холбооны Гадаад бодлого, аюулгүй байдлын
Дээд төлөөлөгч бөгөөд Европын Комиссын Дэд
ерөнхийлөгч Жосеп Боррелийн илгээлт

"ЕВРОП БОЛОН АЗИ ТИВИЙН ХАМТЫН ХҮЧИЙГ БОДИТ ТҮНШЛЭЛ РҮҮ ХӨТЛӨХ ЦАГ НЬ НЭГЭНТ БОЛСОН"

Миний бие өчигдөр болон өнөөдөр 12-р сарын 16-ны Даваа гарагт Испанийн Мадрид хотод зохион байгуулагдаж байгаа Ази, Европын уулзалт буюу АСЕМ-ын дээд түвшний уулзалтыг даргалж байгаадаа нэн таатай байна. АСЕМ гэх энэ товчлол нь манай хоёр тивийн хувьд улс төрийн нэн өндөр ач холбогдолтой билээ. Намайг Испанийн Гадаад харилцааны сайдын албыг хашиж байх үед АСЕМ-ын дээд түвшний уулзалтыг Мадрид хотод зохион байгуулах саналыг тавьж байв. Харин өнөөдөр Европын Холбооны Гадаад харилцаа, аюулгүй байдлын асуудал хариуцсан Дээд төлөөлөгчийн хувьд энэ дээд хэмжээний уулзалтыг даргалж байгаа нь хурдацтай хөгжиж буй Ази тив бол Европ төдийгүй миний хувь хүний сонирхлыг онцгойлон татаж байгааг илтгэж байна.

АСЕМ бол Ази, Европын орнуудын эрх тэгш харилцаанд суурилсан улс төр, эдийн засаг, нийгэм соёлын нийтлэг тулгамдсан асуудлыг хэлэлцдэг Засгийн газар хоорондын албан бус яриа хэлэлцээний хамтын ажиллагааны байгууллага бөгөөд АСЕМ-д

- Дэлхийн худалдааны 55%
- Дэлхийн ДНБ-ий 60%
- Дэлхийн хүн амын 60%
- Дэлхийн аялал жуулчлалын 75% хувийг эзэлдэг 51 орон, Европын комисс, АСЕАН-ны нарийн бичгийн дарга нарын газар гэсэн олон улсын 2 байгууллага багтдаг юм.

Улс хоорондын уулзалт зохион байгуулах нь зарим тохиолдолд ямар нэгэн үр дүнд хүргэхгүй байж болох ч шинэ тутам боломжийг бий болгож байдаг. Сүүлийн жилүүдэд АСЕМ-ын дээд хэмжээний уулзалтууд цаг үеэ мэдэрсэн, стратегийн хувьд өндөр ач холбогдолтой болсоор байна. Энэ жилийн АСЕМ-ын уулзалт нь Европ, Азийн хамтын ажиллагааг улам бэхжүүлэх чухал боломж болно гэдэгт огтхон ч эргэлзэхгүй байна.

Тогтвортой хөгжлийн зорилтуудыг бэхжүүлж, хууль журмаа дээдэлсэн олон улсын худалдаа, хил дамнасан мэдээлэл солилцоо, мөргөлдөөнөөс урьдчилан сэргийлсэн буюу энхийн замаар аливаа асуудлуудыг шийдвэрлэхэд бүс нутгийн хамтын ажиллагааны тэр дундаа АСЕМ-ын үүрэг оролцоо улам бүр өсөн нэмэгдэж байна. АСЕМ нь хууль дүрэмд суурилсан, олон ургалч, олон талт үзлийг хүндэтгэх, сурталчлах гол тавцан нэгэнтээ болсон төдийгүй энэ цаг үед дэлхий дахинд гарч буй өөрчлөлт, сорилт нь ийм төрлийн хамтын ажиллагаа, манлайллыг зайлшгүй шаардаж байна.

Нэмж хэлэхэд, Европын Холбоо нь Дэлхийн хамтын нийгэмлэгийн өмнө тулгамдаж буй асуудлууд болох Солонгосын хойг, Рахайн мужид үүссэн нөхцөл байдал, Ойрх Дорнодын энх тайвны үйл явц, Иран, Афганистанд энх тайвныг тогтоох хүчин чармайлт зэрэг чиглэлд идэвхтэй анхааран ажиллаж байна. Бид аюулгүй байдлын тулгамдсан асуудлыг шийдвэрлэх, олон ургалч, олон талт үзэл, жендерийн тэгш байдал, эмэгтэйчүүдийн эрхийг дэмжих чиглэлээр ажиллаж байна.

Европын Холбооны Дээд төлөөлөгчөөр ажиллах хугацаандаа миний бие Европын Холбооны гадаад бодлогыг бодит байдалд суурилж, бат бөх түншлэлд тулгуурлан хэрэгжүүлэх болно. Африк тив болон Баруун Балканы орнуудтай түншлэл хамтын ажиллагаа, Ливийн нөхцөл байдал болон Украины зүүн хэсгийн маргааныг тайван замаар шийдвэрлэх зэрэг олон чухал асуудлаар Азийн түншүүдтэйгээ нягт хамтран ажиллахыг хүсэж байна.

Эдгээр болон бусад олон асуудлыг улс төрийн яриа хэлэлцээрийн үеэр хөндөх болно.

Оюутан солилцоо, бизнесийн хамтын ажиллагаа, аялал жуулчлал, эрдэмтэн судлаачдын хооронд туршлага хуваалцах зэрэг олон чиглэлээр Ази Европын харилцаа хамтын ажиллагаа өдөр тутам өрнөсөөр байна.

АСЕМ-ын дээд хэмжээний уулзалт бол хоёр хүчирхэг тивийн иргэд хоорондын уялдаа холбоог улам бүр бэхжүүлэх орчин нөхцлийг бүрдүүлж өгөх чин зорилт бүхий боломж юм. Өнөөдөр Испани Улсын Мадрид хотод болж буй АСЕМ-ын дээд хэмжээний уулзалтын үеэр, мөн дараа дараагийн уулзалтуудаар Азийн түнш болон найз нөхөдтэйгөө дахин уулзахын ерөөлийг дэвшүүлэе.

Европ болон Ази тивийн хамтын хүчийг бодит түншлэл рүү хөтлөх цаг нь нэгэнт болсон.



The Defacto Gazette

МЭДЭЭЛНЭ | ЗОРИГЖУУЛНА | МЭДЭЛЖҮҮЛНЭ

ДАВАА ГАРАГ БҮР



НЭГ УЛИРЛЫН ҮНЭ
30.000₮

МОНГОЛ ШУУДАН
7007-8916

WWW.MONGOLPOST.MN



ДеФакто **ТОЙМ**

Ням гараг бүр VTV телевизээр 21 цагт гардаг Дефакто тоймын эмхэтгэл:
2019.12.15-ны дугаар

Долоо хоног бүрийн тойм, <http://jargaldefacto.com/category/12>

МОНГОЛ УЛС ХҮНИЙ ХӨГЖЛИЙН ӨНДӨР ҮЗҮҮЛЭЛТТЭЙ ОРОНД БАГТЛАА

НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөрөөс эрхлэн бэлтгэдэг Хүний хөгжлийн илтгэлийг танилцууллаа. 189 орныг дундаж наслалт, сургуульд суралцах хугацаа, нэг хүнд ногдох үндэсний нийт орлого (GNI per capita based on PPP) гэсэн 3 үндсэн үзүүлэлтээр хэмжиж эрэмбэлдэг. Үүнээс хүний маш өндөр хөгжилтэй 62 орон, өндөр хөгжилтэй 54 орон, дунд хөгжилтэй 37 орон, сул хөгжилтэй 36 орон байна. Монгол улс энэ жилийн тайлангаар 92 дугаарт буюу хүний хөгжлийн өндөр үзүүлэлттэй оронд багтжээ. Харин Орос 49-рт буюу маш өндөр үзүүлэлттэй улс, Хятад 85-рт буюу өндөр үзүүлэлттэй орны тоонд оржээ. Монгол улс 2017 онд 94-рт байснаас энэ жил 92-рт орсон нь зарчмын хувьд яг адилхан байр.

HUMAN DEVELOPMENT INDEX AND ITS COMPONENTS

TABLE 1			SDG 3	SDG 4.3	SDG 4.6	SDG 8.5		
	Human Development Index (HDI)		Life expectancy at birth	Expected years of schooling	Mean years of schooling	Gross national income (GNI) per capita	GNI per capita rank minus HDI rank	HDI rank
	Value		(years)	(years)	(years)	(2011 PPP \$)		
HDI rank	2018		2018	2018 ^a	2018 ^a	2018	2018	2017
1	Norway	0.954	82.3	18.1 ^b	12.6	68,059	5	1
49	Russian Federation	0.824	72.4	15.5	12.0 ^c	25,036	2	49
85	China	0.758	76.7	13.9 ^e	7.9 ^m	16,127	-13	86
92	Mongolia	0.735	69.7	14.2 ^e	10.2 ^e	10,784	7	94
189	Niger	0.377	62.0	6.5	2.0 ^e	912	-3	189


НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөрийн Суурин төлөөлөгч хатагтай Илейн Конкиевич

“Монгол улс энэ удаагийн тайлангаар хүний хөгжлийн өндөр үзүүлэлттэй оронд багтаж буй нь сайн хэрэг ч өнгөрсөн жилүүдийн 92 дахь байрнаас урагшлаагүй байна. Хүний хөгжил гэдэг нь тогтмол тоон дүн бус улс орны хөгжил дэвшлийн хувьсан өөрчлөгдөж байдаг ойлголт юм. 2030 он гэхэд энэ байрыг 70 дотор болгон урагшлуулах зорилгыг Монгол улсын алсын хараа 2030 баримт бичигт дэвшүүлсэн бөгөөд бид энэ зорилгыг биелүүлэхийн төлөө хичээх ёстой”

Монгол улс дахь НҮБ-ын Суурин зохицуулагч ноён Тапан Мишра

“Хүн бүрийн саналыг тусгаж чадаагүй шийдвэр олшрох аваас бидэнд тулгамдаж буй жинхэнэ, бодит асуудал шийдэгдэлгүй үлдэнэ. 2030 он гэхэд Тогтвортой хөгжлийн зорилгуудад хүрсэн байхын тулд тэгш байдлыг хангах нь нэн чухал. Тиймээс Монгол улс цаашид тэгш бус байдлыг бууруулж, хүн бүрт хүртээмжтэй өсөлтийг хангахыг чухалчилна гэдэгт итгэлтэй байна”

ЗАСГИЙН ГАЗРЫН ШИЙДВЭРҮҮД ЯАГААД БУЦДАГ БОЛЧИХОВ ОО?



Гэрэл зургийг: MNB

12-р сарын 2-нд Нийслэлийн ИТХ-ын ээлжит хуралдаанаар “Авто зам ашигласны төлбөрийн хувь хэмжээг шинэчлэн тогтоох тухай” төслийг дэмжиж баталсан. Гэтэл үүнийг эсэргүүцэж автомашинтай жагсаал болсон. Үүний дараа Ерөнхий сайд энэ асуудлаа дахин судал гэж хотын даргад үүрэг болгосон. Эцэст нь зам ашигласны төлбөрийг нэмэх асуудал цуцлагдсан.

Энэ мэтчилэн төрийн удирдлагуудын гаргасан шийдвэр буцаж байгаад 2 шалтгаан байна гэж харж байна. **Эхнийх**, төр засаг нь шийдвэр гаргаж чадахгүй, гаргасныг нь иргэд нь хүлээж авахгүй байгаа бол засаглал өөрөө хямралтай байна гэсэн үг. МУ-ын засаглал ил тод биш, иргэдийн санал гомдолд хариу өгөхгүй удсантай холбоотой. Иймээс иргэдэд бухимдал бий болж байна л даа. **Хоёрт**, төрийн шийдвэр гаргах тогтолцоо захиргааны шинжтэй байгаагийн тод жишээ бол энэ үйл явдал. Хэн нэг дарга нэг өглөө босоод “таны төлдөг байсан төлбөрийг 5 дахин нэмэхээр шийдлээ, төлөөрэй” гэдэг аргаар явахгүй л дээ. Аливаа шийдвэрийг гаргахдаа

урт хугацаанд судалгаа хийж, иргэдийн санал бодлыг тандаж дүгнэсэн байх ёстой.

Зам ашигласны төлбөрийг автомашины төрөл, хэмжээнээс хамаарч нэмэх гэдэг нь логикийн хувьд зөв ажил л даа. Гэхдээ яагаад 5 дахин нэмэгдүүлэх шаардлага үүссэн бэ? Өмнө нь авдаг байсан төлбөр яагаад хүрэхгүй болсон бэ? Нэмэгдсэн төлбөр ямар ажилд зарцуулагдах талаар иргэд жагсаад үүдэнд нь хашгирсны дараа биш шийдвэр гаргахаасаа өмнө гарч ирээд тайлбарлах хэрэгтэй байсан.

Улаанбаатар хотын иргэд даргаа өөрсдөө шууд сонгодог болъё. Хотын хог, зам зэрэг аж ахуйн асуудлууд улс төрд ямар хамаа байна аа. Одоо бол улс төрийн нам хотын даргыг томилж байгаа учраас тэднээс хараат бус ажиллах боломжгүй, чадахгүй. Хүн амын хагас нь амьдарч байгаа нийслэлд үнэхээр бодитой аж ахуйн удирдлага шаардлагатай.

САЙД Ц.НЯМДОРЖИЙН ХУУЛЬЧДЫН ХОЛБООГ ТАТАН БУУЛГАХ САНАЛ

Улсын их хурал 2019 оны 10-р сарын 18-нд Өмгөөллийн тухай хуулийг дагалдах хуулиудын хамт баталсан. Энэ хуульд “Өмгөөлөгчдийн холбоо” байгуулна гэсэн байгаа ба үүнд нь Ерөнхийлөгч хориг тавьсан. Гэтэл Хууль зүйн байнгын хороо “Өмгөөлөгчдийн холбоог” байгуулахгүй гэсэн хоригийг хүлээн аваагүй. Мөн Хууль зүйн сайд Ц.Нямдорж одоо байгаа Хуульчдын холбоог татан буулгана гэж хэллээ.

Энэ бол эрх мэдлийн төлөө байлдаан л даа. Уг нь мэргэжлийн холбоод, ТББ-ууд төрөөс нэлээн зайтай байх ёстой.



Ц. НЯМДОРЖ

Б.БАЯР

Сайд Ц. Нямдорж: “Хуульчдын холбоог би татан буулгах санал оруулж ирнэ. Уг нь байж байг гэж бодсон юм. Гэтэл үймүүлээд болохгүй юм шиг байна” гэж хэлжээ. Харин хуульч, өмгөөлөгч Б.Баяр “Сайд Ц.Нямдоржийн хэлсэн энэ үг нь Хууль бус. Аливаа нэг байгууллагыг оршин тогтнох эсэх, үйл ажиллагаа явуулах эсэх эсвэл татан буулгах эсэхийг хөндлөнгийн хэн нэгэн хүн “өршөөж” эсвэл “хашрааж” шийддэггүй

юм. Хуульчийн эрх зүйн байдлын тухай хууль, Төрийн бус байгууллагын тухай хууль, Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуульд аливаа байгууллагыг үүсгэн байгуулах, татан буулгах асуудлыг зохицуулсан. Нэг сайдын “байж байг гэж бодсон юм” гэдэг өршөөл, ивээлээр үйл ажиллагаа явуулж, “үймүүлээд байна” гэдэг дүгнэлтээр татан буулгадаггүй юм. Та Хууль зүй, дотоод хэргийн сайд болохоос дундад зууны хэмжээгүй эрхт хаан, хоригдлын амьд явах эсэхийг шийддэг, 1944 оны дэлхийн хоёрдугаар дайны үеийн концлагерын коммендант биш, энэ зуун 21 дүгээр зуун” гэж тайлбарласан.

Судлаачид “Өмгөөллийн тухай хууль энэ чигээрээ мөрдөгдөөд явбал эрх зүйн хэм хэмжээнд ноцтой хийдэл үүснэ. Тодруулбал, хуульч, өмгөөлөгчдийн үйл ажиллагааны чиг үүрэг, эрх ашгийг хамгаалах, мэргэжлийн сургалт зэрэг нэгдмэл тогтолцоо алдагдаад хоёрдмол тогтолцоо руу орчихно. Эцэстээ шүүгч шүүгчийнхээ асуудлыг, прокурор прокурорынхоо, өмгөөлөгч өмгөөлөгчийнхөө ёс зүйн асуудлыг шийддэг 2013 оны өмнөх байдал руу буцаж орвол монголд хуульчийн хариуцлагын тогтолцоог сулруулсан, хариуцлага тооцож чаддаггүй, ухралт болно” гэж байр сууриа илэрхийлсээр байна.

*Дефакто тоймын гол агуулгыг хураангуйлан бэлтгэв
Тоймын бүрэн эхийг jargaldefacto.com вебсайтаас үзэх боломжтой.*

Та “Дефакто Газет” цахим сонинг тогтмол хүлээн авахыг хүсвэл
www.jargaldefacto.com болон www.defacto.mn вебсайтад өөрийн имейлээ бүртгүүлнэ

РЕДАКЦЫН ЗӨВЛӨЛ

Ерөнхий эрхлэгч:
Дамбадаржаагийн Жаргалсайхан
Ерөнхий Редактор:
Ганбаатарын Жавзмаа

ГҮЙЦЭТГЭЛИЙН БАГ

Отгонсүрэнгийн Билгүүн
Адъяагийн Тунгалаг

ХОЛБОО БАРИХ

✉ editor1@jargaldefacto.com
☎ +976 94109342
🌐 www.defacto.mn
www.jargaldefacto.com